



“СҮЛД-АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“БАРИЛГА” ХК

*2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон
санхүүгийн тайлан*

Улаанбаатар хот

2023 он



БАРИЛГА ХК

**2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:**

“СҮЛД-АУДИТ” ХХК
Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Сүхбаатар дүүрэг, Бага
тойруу, 8-р хороо, 11-р хороолол
GB center 502 тоот

Утас: 70118016
Web: www.suld-audit.mn

**АУДИТЫН ДУУСГАВАР БОЛГОСОН
ТУХАЙ ТАЙЛАН**

АГУУЛГА

	ХУУДАС
- Байгууллагын талаарх мэдээлэл	2
- Удирдлагын хариуцлагын захидал	3
- Аудиторын дүгнэлт	4
- Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	6
- Удирдлагад хүргэх захидал	10
- Аудиторын тайлангийн тодруулга	11
- Санхүүгийн тайлангийн тодруулга	14
- Удирдлагад өгөх зөвлөмж	17

2023 оны 04 дүгээр сарын 03

“ БАРИЛГА ” ХК**Байгууллагын талаарх мэдээлэл****Байгуулах шийдвэр**

Барилга ХК (“Компани”) нь 1996 онд 406,620.0 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан.

Барилга ХК нь 2007 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлснээр 2069822 тоот регистрийн дугаар бүхий 9010001058 дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

Захирал**Ерөнхий ня-бо**

Ш.Эрдэнэбат
Э. Батсүх

Байнгын хаяг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
4 дүгээр хороо, Барилгачдын талбай
Өөрийн байр
Утас: 99115254, факс 321420

Аудитор

“СҮЛД-АУДИТ” ХХК
Улаанбаатар хот, Монгол улс
Сүхбаатар дүүрэг 8-р хороо
11-р хороолол, Бага тойруу
GB цент 502 тоот
Утас: 976-11-70118016
e-mail: info@suld-audit.mn



“БАРИЛГА” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2023.04.03 № 23/27
танай _____ -ны № _____

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хязгаарлалттай дүгнэлт

Бид “Барилга” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр *Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл* хэсэгт тайлбарласан зүйлийн үр нөлөөг эс тооцвол, “Барилга” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүү байдлын тайлан, тухайн одроор дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд эрх бүхий байгууллагын баталсан холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл

1. Касс дахь бэлэн мөнгөн хөрөнгийн 1,083,056.7 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулах анхан шатны нотлох баримт байхгүй.
2. Санхүүгийн тайланд жилийн эцсээр их хэмжээний авлага оглог тайлагнагдсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5.6 дах заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалтай дүгнэлтийн үндэслэл гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хариуцлага хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага байгууллагын үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.



Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, оорийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


ХҮНДЭТГЭСЭН,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, МНБ



Ч.Гүндбаяр

“БАРИЛГА” ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тэм	12/31/2021	12/31/2022
<i>/төгрөгөөр/</i>			
А. ХӨРӨНГӨ			
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	3,337,482,975.55	4,823,978,594.10
Дансны авлага	2	7,960,732,546.09	12,244,161,061.93
Татвар, НДШ-ийн авлага		-	-
Бусад авлага	2	55,764,810.10	32,764,810.10
Бараа материал	3	723,500,482.07	470,702,837.61
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	4	2,098,368,038.50	975,868,627.82
Эргэлтийн хөрөнгийн дүн		14,175,848,852.31	18,547,475,931.56
2. Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	5	13,725,797,615.28	13,936,706,027.45
Биет бус хөрөнгө		45,000.00	45,000.00
Бусад эргэлтийн бус хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		13,725,842,615.28	13,936,751,027.45
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		27,901,691,467.59	32,484,226,959.01
Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
1. Өр төлбөр			
Дансны өглөг	6	124,365,162.60	582,267,294.82
Цалингийн өглөг	6	15,775,309.24	16,525,196.06
Татварын өр	6	68,228,544.34	919,617,011.09
НДШ-ийн өглөг	6	92,695,883.49	533,319,594.00
Богино хугацаат зээл			
Хүүний өглөг			
Ноогдол ашгийг өглөг	6	23,702,844.55	41,371,894.55
Бусад богино хугацаат өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөрийн дүн		324,767,744.22	2,093,100,990.52
Урт хугацаат зээл			
Бусад урт хугацаат зээл			
Урт хугацаат өр төлбөрийн дүн			
Өр төлбөрийн нийт дүн		324,767,744.22	2,093,100,990.52
2. Эздийн өмч			
б. Хувийн	7	2,500,713,000.00	2,500,713,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7	9,988,509,155.66	9,988,509,155.66
Хуримтлагдсан ашиг, алдагдал	7	15,087,701.71	17,901,903,812.83
Эздийн өмчийн дүн		27,576,923,723.37	30,391,125,968.49
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		27,901,691,467.59	32,484,226,959.01


Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“БАРИЛГА” ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тэм	/төгрөгөөр/	
		12/31/2021	12/31/2022
Борлуулалтын орлого(цэвэр)	8	996,968,444.75	27,267,234,713.47
Борлуулалтын өртөг		763,140,832.41	20,649,042,796.56
Нийт ашиг /алдагдал/		233,827,612.34	6,618,191,916.91
Түрээсийн орлого	9	291,437,824.73	260,522,605.94
Хүүгийн орлого	9	422,802,739.73	240,000,000.00
Ногдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Бусад орлого			
Борлуулалт, маркетингийн зардал			
Ерөнхий ба удирдлагын зардал	10	1,445,068,945.55	4,016,234,520.38
Санхүүгийн зардал			
Бусад зардал			
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(1,368,466.13)	(18,316,329.70)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			58,650,000.00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)		(4,167,798.64)	(3,319,283.27)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(502,537,033.52)	3,139,494,389.50
Орлогын татварын зардал		42,280,273.97	304,961,144.40
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		(544,817,307.49)	2,834,533,245.10
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(544,817,307.49)	2,834,533,245.10
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
Орлогын нийт дүн		(544,817,307.49)	2,834,533,245.10
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.




“БАРИЛГА” ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний өдөр	2,500,713,000.00		827,962,633.48	15,652,849,875.21	18,981,525,508.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нолоо, алдааны залруулга	-				
Залруулсан үлдэгдэл	2,500,713,000.00		827,962,633.48	15,087,701,567.70	18,416,377,201.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,834,533,245.10	2,834,533,245.10
Бусад дэлгэрэнгүй орлого			9,160,546,522.18		9,160,546,522.18
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг				(20,331,000.00)	(20,331,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2022 оны 12-р сарын 31-ний өдөр	2,500,713,000.00		9,988,509,155.66	17,901,903,812.80	30,391,125,968.49


Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“БАРИЛГА” ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

	/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2021	12/31/2022
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,906,628,985.36	25,745,280,208.75
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	2,496,217,137.81	25,739,944,218.48
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар	(25,327,926.18)	(357,643,113.67)
Бусад орлого	435,739,773.73	362,979,103.94
Мөнгөн зарлагын дүн (-)	3,616,502,977.73	24,301,106,046.82
Ажиллагчдад төлсөн	772,404,591.49	7,025,577,279.40
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	201,853,380.17	1,698,038,719.35
Бараа материал худалдан авахад төлсөн	336,712,611.48	6,959,947,907.59
Ашиглалтын зардалд төлсөн	36,220,207.35	237,753,079.36
Түлш шатахуун, тээврийн хөлс төлсөн	1,274,545.46	265,275,277.81
Хүүний төлбөрт төлсөн	21,027,987.48	63,966,732.12
Татварын байгууллагад төлсөн	360,265,037.38	937,495,504.87
Даатгалын төлбөрт төлсөн	221,670.00	450,703,517.24
Бусад мөнгөн зарлага	1,886,522,946.92	6,662,348,029.08
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(709,873,992.37)	1,444,174,161.93
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	421,308,971.55	63,149,236.36
Мөнгөн орлогын дүн (+)	422,802,739.73	312,900,000.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		96,900,000.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаан буцаан олголт		
Хүлээн авсан хүүний орлого	422,802,739.73	216,000,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,493,768.18	249,750,763.64
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,493,768.18	249,750,763.64
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	421,308,971.55	63,149,236.36
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		68,515.71
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Бусад		68,515.71
Мөнгөн зарлагын дүн (-)	1,368,466.15	20,896,295.40
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		2,511,450.00
Бусад	1,368,466.15	18,384,845.40
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,368,466.15)	(20,824,779.69)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(289,933,486.97)	1,486,495,618.60
<i>Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	<i>3,627,416,462.45</i>	<i>3,337,482,975.48</i>
<i>Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	<i>3,337,482,975.48</i>	<i>4,823,978,594.08</i>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ**БАРИЛГА ХК-ИЙН
УДИРДЛАГАД**


“БАРИЛГА” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарал татсан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү тайланд багтаасан болно.

Санхүүгийн тайлангийн аудитыг Аудитын Олон Улсын Стандарт болон аудитын горимын дагуу хийж гүйцэтгэх явцад бидний анхаарал татсан тодорхой зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор аудитын тайланг толилуулав.

“БАРИЛГА” ХК-ийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан болно. Санхүүгийн тайланд аудит хийх явцад ажиглагдсан бидний өгсөн зөвлөмжийг анхаарч, хүлээн авч, хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэж байна. Түүнчлэн тайланд бичигдсэн зөвлөмжийн талаар ярилцах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд туслалахад бэлэн байх болно.

Аудитын ажлын явцад бидэнтэй хамтран ажиллаж, туслалцаа үзүүлж байсан “БАРИЛГА” ХК-ийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Захирал


Ч. Гүндбаяр М14Б

“БАРИЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ**2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ТЭМДЭГЛЭЛ****1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

/а/ Компанийн үндсэн үйл ажиллагаа

- ✚ Гадаад худалдаа
- ✚ Орон сууц болон оффисын барилгын ашиглалт үйлчилгээ, аюулгүй байдал

/б/ Ажиллагсадын тоо нийт - 26

- ✚ Удирдах ажилтан - 3
- ✚ Гүйцэтгэх ажилтан - 23

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГЫН ХУРААНГУЙ

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримтладаг.

✚ Тайлан бэлтгэсэн үндэслэл**а/ Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий суурь**

Санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртгийн суурьд үндэслэн, компанийн тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдэж, төгрөг мөнгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

б/ Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын тосоолол хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

в/ Мөнгө ба түүнтэй адилтгах орлого

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө /барьцаалсан хадгаламжийг оруулахгүй/-өөс бүрдэнэ.


г/ Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют /төгрөг/ руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагын гүйлгээнүүдийг гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

д/ Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.



е/ Бараа материал

Бараа материалууд нь түүхэн өртгөөрөө илэрхийлэгддэг. Бараа материалын өртөгт бараа материалыг худалдан авсан үнэд ноогдох гаалийн болон бусад татвар хураамж, одоогийн байршил, нөхцөлд авчрахад гаргасан бүхий л зардлууд (тээвэрлэлтийн зардал орохгүй)-ыг тооцоолж бараа материал дансанд бүртгэдэг. Бараа материалыг зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

ё/ Урьдчилж төлсөн зардал

Үйл ажиллагааны зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрөх хүртэл урьдчилж төлсөн зардлаар тайлагнадаг. Урьдчилж төлсөн зардлыг төлсөн хэмжээгээр буюу нэрлэсэн үнээр илэрхийлнэ.

ж/ Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө гэж эргэлтийн бус хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөж авах зориулалттай хөрөнгө ба уг хөрөнгийг дансны үнэ болон бодин үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь хэмжиж бүртгэдэг байна.

з/ Үндсэн хөрөнгө ба түүний элэгдэл***Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт***

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн үндсэн хөрөнгүүдийг ашиглахад бэлэн болгохтой холбоотой гарсан бусад зардал зэргээс бүрдэнэ.

Элэгдэл

Элэгдлийг үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд тусгана. Үндсэн хөрөнгийн ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.


- | | |
|-------------------------------------|--------|
| • Барилга, байгууламж | 40 жил |
| • Машин, тоног тохоромж | 10 жил |
| • Тавилга, эд хөгшил багаж хэрэгсэл | 10 жил |
| • Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| • Компьютер | 3 жил |

и/ Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулдаг.

й/ Дансны болон бусад өглөг

Дансны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.



к/ Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг эдийн засгийн үр ашиг нь компанид орох магадлалтай, бодитойгоор хэмжих боломжтой болсон үед хүлээн зөвшөөрдөг. Борлуулсан бүтээгдэхүүнээс олсон орлого нь НӨАТ болон бусад татвар хөнгөлөлт, урамшуулал, буцаалт, худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг хассан цэвэр дүнгээр хүлээн авсан эсвэл хүлээн авах бодит үнэ цэнээр хэмжигддэг. Дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Үүнд:

- Тухайн бүтээгдэхүүний өмчлөлийн голлох эрсдэл болон өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн
- Борлуулсан барааны удирдлага болон хяналтын аль аль нь компанид үлдээгүй
- Хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ нь хэмжиж болохоор байх
- Ажил гүйлгээний урсгал нь компанид эдийн засгийн өгөөж өгөх магадлалтай байх
- Ажил гүйлгээний холбоотой гарсан болон гарах өртөг, буцаалтын тооцооллыг найдвартай хэмжих боломжтой байх

л/ Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

- ✚ **Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал** - Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр тологдсонөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

м/ Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлогод харилцах дансанд бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана. Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардлыг хамруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

н/ Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татварын хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг байна.

р/ Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ба уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Эдгээр тэмдэглэлүүд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.



**БАРИЛГА ХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

1. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

(төгрөгөөр)

Төрөл	Валютын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Касс дахь бэлэн мөнгө	төгрөг	336,568,823.51	1,083,056,697.58
Харилцах – Голомт банк	төгрөг	914,152.04	921,896.51
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	төгрөг	3,000,000,000.00	3,740,000,000.00
Нийт дүн		3,337,482,975.55	4,823,978,594.09

Тайлбар: БАРИЛГА ХК Голомт банкны нийт 2 харилцахын данстай ба 921,896.51 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулсан болно. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 1,083,056,697.58 мянган төгрөг ба тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

2. ДАНСНЫ АВЛАГА

а. Дансны авлага

(төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны авлага	7,960,732,546.09	12,244,161,061.93
Нийт дүн	7,960,732,546.09	12,244,161,061.93

б. Бусад богино хугацаат авлага

(төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Ажиллагчдаас авах авлага	55,764,810.00	32,764,810.10
Нийт дүн	55,764,810.00	32,764,810.10

3. БАРАА МАТЕРИАЛ

(төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бараа материал	723,500,482.07	470,702,837.62
Нийт дүн	723,500,482.07	470,702,837.62

4. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

(төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Урьдчилгаа	2,098,368,038.50	975,867,627.82
Нийт дүн	2,098,368,038.50	975,867,627.82

5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

а. Үндсэн хөрөнгө

(төгрөгөөр)

Үндсэн хөрөнгийн төрөл	Эхний үлдэгдэл	Байгуулсан элэгдэл	Эцсийн үлдэгдэл
Барилга, байгууламж	14,051,266,120.00	2,573,385,052.52	11,477,881,067.50
Машин тоног төхөөрөмж	772,943,830.96	398,929,656.46	374,014,274.50
Багаж хэрэгсэл	535,376,428.61	79,561,973.97	455,814,454.64

Тээврийн хэрэгсэл	1,761,314,401.86	989,551,739.27	771,762,662.59
Тавилга эд хогшил	95,904,658.38	85,633,293.67	10,271,364.71
Компьютер, бусад хэрэгсэл	157,122,484.10	100,160,180.57	56,962,303.53
Газар	790,000,000.00		790,000,000.00
Нийт дүн	18,163,927,923.91	4,227,221,896.46	- 13,936,706,027.45
Үндсэн хөрөнгө (цэвэр) дүн			13,936,706,027.45

6. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

а. Дансны өглөг (төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны өглөг	124,365,162.60	582,267,294.82
Нийт дүн	124,365,162.60	582,267,294.82

б. Цалингийн өглөг (төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Цалингийн өглөг	15,775,309.36	16,525,196.06
Нийт дүн	15,775,309.36	16,525,196.06

в. НДШ, Татварын өглөг (төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ААНОАТ өглөг	(45,043,566.87)	(71,105,843.21)
ХХОАТ-ын өглөг	46,431,824.38	394,290,012.59
ҮХХАТ-ын өглөг	33,053,018.18	20,176,805.43
НӨАТ-ын өглөг	33,787,268.65	576,256,036.27
НДШ-ийн өглөг	92,695,883.49	553,319,594.00
Нийт дүн	160,924,427.83	1,472,936,605.08

6. Ногдол ашгийн өглөг

(төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Ногдол ашиг өглөг	23,702,844.55	41,371,894.55
Нийт дүн	23,702,844.55	41,371,894.55

7. ЭЗНИЙ ӨМЧ

а. Хувийн өмч


(төгрөгөөр)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хувийн өмч	2,500,713,000.00	2,500,713,000.00
Нийт дүн	2,500,713,000.00	2,500,713,000.00

б. Хуримтлагдсан ашиг/ Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

(төгрөгөөр)

Эхний үлдэгдэл	Ногдол ашиг	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эцсийн үлдэгдэл
9,988,509,155.66			9,988,509,155.66
15,087,701,567.71	20,331,000.00	2,834,533,245.10	17,901,903,812.81



8. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

(төгрөгөөр)

Төрөл	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Борлуулалтын орлого	996,968,444.75	27,267,234,713.47	26,270,266,268.72
Нийт орлогын дүн	996,968,444.75	27,267,234,713.47	26,270,266,268.72

9. БУСАД ОРЛОГО

(төгрөгөөр)

Төрөл	Өмнөх он	Тайлант он
Бусад орлого	714,240,564.46	500,522,605.94
Нийт дүн	714,240,564.46	500,522,605.94

10. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(төгрөгөөр)

Төрөл	Тайлант он	Бүтэц
Ажиллагчдын цалингийн зардал	649,581,719.16	16.2%
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	1,184,917,991.13	29.5%
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	140,385,897.80	3.5%
Бичиг хэргийн зардал	13,473,277.39	0.2%
Шуудан холбооны зардал	11,532,143.18	0.7%
Даатгалын зардал	480,703,517.24	11.9%
Ашиглалтын зардал	237,753,079.36	5.9%
Засварын зардал	19,449,209.09	0.48%
Элэгдэл, хорогдлын зардал	730,901,782.90	18.1%
Түрээсийн зардал	137,732,318.18	3.4%
Тээврийн зардал	265,018,623.72	6.5%
Зар сурталчилгааны зардал	516,363.64	0.06%
Шатахууны зардал	256,654.09	0.07%
Сургалтын зардал	42,292,000.00	0.10%
Зээлийн хүүгийн зардал	63,966,732.12	0.15%
Түүхий эд материалын зардал	15,625,578.73	
Банкны шимтгэл	1,650,881.74	0.04%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал	19,222,928.18	0.006%
Шагнал урамшуулал зардал	244,890.00	
Бусад зардал	4,008,932.73	0.009%
Зардлын нийт дүн	4,016,234,520.38	100.0%

11. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлангийн өдөр болон аудитын тайлан бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.

УДИРДЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв.

Асуудал 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**Бодит байдал**

- Барилга ХК нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, дагаж мөрдөөгүй байна.

Зөвлөмж

- Цаашид байгууллагын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох үүднээс мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т зааснаар "...Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана..." гэсэн үүргийг аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад хариуцуулсан билээ.

Иймд байгууллага нь оорийн салбарын онцлогыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж байгаа санхүү, Нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, салбарын дээд газрын дүрэм журамд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо шинээр боловсруулан, мөрдөн ажиллах нь зүйтэй.

Асуудал 1. Авлага, оглогийн тооцооны талаар**Бодит байдал**

- Тайлант хугацааны эцэс дэх 71,105.8 мянган тогрогийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг оглог дансанд хасах үлдэгдэлтэй тайлагнагдсанаас оглог, авлагын үлдэгдэл буруу тайлагнагдаж байна.

Зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д зааснаар "Дансны оглог, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтын хэрэгжүүлж ажиллах.

